

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

**ЭМ АЙ ДИ ЭЙ ЭС ҮЦК ХХК-ийн
2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР
ДУУСГАВАР БОЛГОСОН ХААЛТЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо Бага тойруу/14200/, Сүхбаатарын
талбай гудамж 8/1, СИТИ ТАУЭР, 15 давхар 1504/2 тоот.

Утас: 77551090

И-мэйл: info@silversoroban.mn Вэб хуудас: www.silversoroban.mn

АГУУЛГА

Компанийн ерөнхий мэдээлэл

Хараат бус аудиторын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31 ний өдрөөр тасалбар болгосон
аудитлагдсан санхүүгийн тайлан

- ✓ Санхүүгийн байдлын тайлан
- ✓ Орлогын дэлгэрэнгүй тайлан
- ✓ Өмчийн өөрчлөлтийн тайлан
- ✓ Мөнгөн гүйлгээний тайлан

Санхүүгийн тайлангийн тодруулгууд:

- ✓ Компанийн зохион байгуулалт ба үйл ажиллагаа
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого



“ЭМ АЙ ДИ ЭЙ ЭС ҮЦК” ХХК-ИЙН МЭДЭЭЛЭЛ

КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ:

“ЭМ АЙ ДИ ЭЙ ЭС ҮЦК” ХХК нь 2012.06.03-ны өдөр Улсын бүртгэлд бүртгүүлсэн.

Регистрийн дугаар: 5717337

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:

Я.ДАШДОРЖ

КОМПАНИЙН ХАЯГ:

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо,
4 улирлын цэцэрлэг, 3-201 тоот

Утас: 99113230, 99992104

АУДИТЫН КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ:

СИЛВЕР СОРОБАН АУДИТ ХХК

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу,
Сүхбаатарын талбай, Сити тауэр 1504/2 тоот

Утас: 77551090

И-мэйл: info@silversoroban.mn

Вэб хуудас: www.silversoroban.mn





“ЭМ АЙ ДИ ЭЙ ЭС ҮЦК” ХХК-ийн
УДИРДЛАГАД

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8-р хороо Бага тойруу/14200/, Сүхбаатарын
талбай гудамж 8/1, СИТИ ТАУЭР, 15
давхар 1504/2 тоот
Утас: (976) 77551090

2025 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/25/189

ХАРААТ БУС АУДИТОРЫН
ТАЙЛАН

ДҮГНЭЛТ

Бид 2024 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “ЭМ АЙ ДИ ЭЙ ЭС ҮЦК” ХХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд “ЭМ АЙ ДИ ЭЙ ЭС ҮЦК” ХХК-ийн 2024 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн зөв, материаллаг алдаагүй үнэн зөв, шударгаар, толилуулж тайлагнасан байна.


Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэсэн. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт тусгасан болно.

Бид санхүүгийн тайлангийн аудитад хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу танай компаниас хараат бусаар ажилласан бөгөөд ёс зүйн дүрэмд заасан шаардлагуудад нийцүүлсэн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт, нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай хэмжээний зохистой үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Бидний хийсэн аудитын ажилд аудитын гол асуудал бол компани нь цаашид тогтвортой үйл ажиллагаа явуулж нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг алдагдуудахгүй байх нь чухал юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.



Санхүүгийн тайлан болон аудиторын тайлангаас бусад мэдээлэл

Санхүүгийн тайлангаас бусад мэдээллийн үнэн зөв байдалд компанийн удирдлага хариуцлага хүлээх ба компани нь жилийн тайландаа бусад мэдээллийг ил тодоор илэрхийлэх үүрэгтэй байдаг. Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй тул бид бусад мэдээлэлд баталгаажуулалт гаргахгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой бидний үүрэг хариуцлага бол бусад мэдээллийг уншиж, уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай эсвэл аудитын явцад олж авсан бидний ойлголттой нийцэж байгаа эсэх эсвэл материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болзошгүй эсэхийг тодорхойлох явдал юм.

Удирдлага болон засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх бүхий этгээдүүд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлан нь залилан болон алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс бүхэлдээ ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин буй материаллаг буруу илэрхийллийг илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан болон алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг хэмжээнд тооцогддог.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайлан нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу “ЭМ АЙ ДИ ЭЙ ЭС ҮЦК” ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчид зориулагдсан ба аливаа нэгэн өөр зорилго агуулаагүй болно.

Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч талын өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.

Хүндэтгэсэн
АУДИТОР



Я.ТЭГШБАТ



АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2023.12.31	2024.12.31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	99,288,819.06	99,276,817.42
Дансны авлага	117,841,900.00	117,841,900.00
Татвар, НДШ – ийн авлага		
Бусад авлага		
Бусад санхүүгийн хөрөнгө		
Бараа материал		
Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
Бусад эргэлтийн хөрөнгө		
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
Эргэлтийн хөрөнгийн дүн	217,130,719.06	217,118,717.42
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	379,500.00	379,500.00
Биет бус хөрөнгө		
Биологийн хөрөнгө		
Урт хугацаат хөрөнгө оруулалт		
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
Хойшлогдсон татварын хөрөнгө		
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
Бусад эргэлтийн бус хөрөнгө		
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	379,500.00	379,500.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	217,510,219.06	217,498,217.42
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
ӨР ТӨЛБӨР		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг		
Цалингийн өглөг	9,642,000.00	59,232,600.00
Татварын өр	454,196.21	1,233,808.60
НДШ - ийн өглөг		
Богино хугацаат зээл	65,491,359.84	85,826,727.71
Хүүний өглөг		
Ногдол ашгийн өглөг		
Урьдчилж орсон орлого		
Нөөц /өр төлбөр/		
Бусад богино хугацаат өр төлбөр		
Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөрийн дүн	75,587,556.05	146,293,136.31

УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР



Урт хугацаат зээл		
Нөөц /өр төлбөр/		
Хойшлогдсон татварын өр		
Бусад урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
Өр төлбөрийн нийт дүн	75,587,556.05	146,293,136.31
ЭЗДИЙН ӨМЧ		
Өмч		
Төрийн		
Хувийн	200,000,000.00	200,000,000.00
Хувьцаат		
Халаасны хувьцаа		
Нэмж төлөгдсөн капитал		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
Эздийн өмчийн бусад хэсэг		
Хуримтлагдсан ашиг	(58,077,336.99)	(128,794,918.89)
Эздийн өмчийн дүн	141,922,663.01	71,205,081.11
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	217,510,219.06	217,498,217.42



АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2023.12.31	2024.12.31
Борлуулалтын орлого		
Борлуулалтын өртөг		
Нийт ашиг (алдагдал)	-	-
Түрээсийн орлого		
Хүүгийн орлого	450,044.57	
Ногдол ашгийн орлого		
Эрхийн шимтгэлийн орлого		
Бусад орлого		
Орлогын дүн	450,044.57	-
Борлуулалт, маркетингийн зардал	31,968,460.00	70,717,581.90
Ерөнхий ба удирдлагын зардал		
Санхүүгийн зардал		
Бусад зардал (ҮАБЗ)		
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
Бусад ашиг (алдагдал)		
Нийт	31,968,460.00	70,717,581.90
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(31,518,415.43)	(70,717,581.90)
Орлогын татварын зардал	45,004.46	
Татварын дараахь ашиг (алдагдал)	(31,563,419.89)	(70,717,581.90)
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(31,563,419.89)	(70,717,581.90)
Бусад дэлгэрэнгүй орлого		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
Бусад олз (гарз)		
Орлогын нийт дүн	(31,563,419.89)	(70,717,581.90)
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		



АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Өмч	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмч бусад	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл				
200,000,000.00			(26,513,917.10)	173,486,082.90
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-
Залруулсан үлдэгдэл	200,000,000.00	-	(26,513,917.10)	173,486,082.90
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(31,563,419.89)	(31,563,419.89)
Бусад дэлгэрэнгүй орлого				
Өмчид гарсан өөрчлөлт				
Зарласан ногдол ашиг				
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл				
200,000,000.00	-	-	(58,077,336.99)	141,922,663.01
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-
Залруулсан үлдэгдэл	200,000,000.00	-	(58,077,336.99)	141,922,663.01
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(70,717,581.90)	(70,717,581.90)
Бусад дэлгэрэнгүй орлого				
Өмчид гарсан өөрчлөлт				-
Зарласан ногдол ашиг				-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл				
200,000,000.00	-	-	(128,794,918.89)	71,205,081.11




АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2023.12.31	2024.12.31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	450,044.57	-
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого		
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Буцаан авсан албан татвар		
Татаас, санхүүжилтийн орлого		
Бусад мөнгөн орлого	450,044.57	
Мөнгөн зарлагын дүн (-)	22,259,425.51	12,001.64
Ажилчдад төлсөн	12,856,000.00	
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,880,860.16	
Бараа материал худалдан авахад төлсөн		
Ашиглалтын зардалд төлсөн	518,040.00	
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн	2,032,299.00	
Даатгалын төлбөрт төлсөн		
Бусад мөнгөн зарлага	3,972,226.35	12,001.64
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(21,809,380.94)	(12,001.64)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	-	-
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого		
Биет бус хөрөнгө борлуулсаны орлого		
Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого		
Бусад урт хугацаат хөрөнгө орлуулсаны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
Хүлээн авсан хүүний орлого		
Хүлээн авсан ногдол ашиг		
Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	5,130,000.00	-
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	5,130,000.00	
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Төрөл бүрийн хандив		
Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
Хувьцаа худалдаж авахад төлсөн		
Төлсөн ногдол ашиг		
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	5,130,000.00	-
Валютын ханшиний зөрүү		
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(16,679,380.94)	(12,001.64)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	115,968,200.00	99,288,819.06
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	99,288,819.06	99,276,817.42



“ЭМ АЙ ДИ ЭЙ ЭС ҮЦК” ХХК

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

ТОДРУУЛГА 1 – Товч танилцуулга

1.1 Байгууллагын тухай

“ЭМ АЙ ДИ ЭЙ ЭС ҮЦК” ХХК

Регистр: 5717337

Захирал:

Я.ДАШДОРЖ

Утас: 99113230, 99992104

Ерөнхий нягтлан бодогч:

Л.НАСАНЖАРГАЛ

Өмчийн хэлбэр: Хувийн

Албан ёсны хаяг: : Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, 4 улирлын цэцэрлэг, 3-201 тоот

Байгууллагын үндсэн үйл ажиллагаа: ХХК

- Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа

Бид аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, Монгол улсад мөрдөгдөж буй аудитын хууль тогтоомжийг баримтлан ажилласан. Аудитын дүгнэлт гаргахдаа тус компаниас бидэнд танилцуулсан санхүүгийн баримт, материалд үндэслэсэн болно.

Аудитын явцад бидэнд танилцуулаагүй аливаа баримт материалаас үүсэх хариуцлагыг манай компани хүлээхгүй юм.

ТОДРУУЛГА 2 – Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого

i. Санхүүгийн тайлагналын суурь

Компанийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу түүхэн өртгийн зарчмаар аккрузл сууриар бэлтгэгдсэн байна.

Компани нь нягтлан бодох бүртгэлээ төгрөгөөр бүртгэдэг ба нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн дагуу явагдаж байна.

ii. Санхүүгийн тайланг бэлтгэсэн байдал

Компани нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэхдээ санхүү бүртгэлийн программ ашиглан гаргадаг.

Санхүүгийн тайлан нь Санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан гэсэн үндсэн 4 тайлантай, санхүүгийн тайлангийн тодруулгуудаас бүрдсэн байна.



“ЭМ АЙ ДИ ЭЙ ЭС ҮЦК” ХХК

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

ТОДРУУЛГА 2 – Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын үргэлжлэл

- iii. **Тасралтгүй үйл ажиллагааны зарчим:** Компанийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа бөгөөд цаашид ч гэсэн үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөлд үндэслэн, тасралтгүй үйл ажиллагааны зарчмаар санхүүгийн тайлангаа бэлтгэдэг. Дээрх тасралтгүй үйл ажиллагааны талаарх төсөөлөл нь үр дүн нь тодорхойгүй байгаа ирээдүйд болж болох үйл явцад суурилсан болно.
- iv. **Санхүүгийн хэрэгслүүд:** Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөр нь балансад мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, авлага, өр төлбөрөөс бүрдэнэ.
- v. **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:** Компанийн хувьд мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь бэлэн мөнгө болон банкин дахь мөнгө, түүнтэй адилтгах зүйлсээс бүрддэг. Мөнгөн хөрөнгийг нэрлэсэн үнээр нь бүртгэлд тусгадаг.
- vi. **Авлага:** Компанийн авлага нь хуримтлуулж тооцсон хүүгийн авлага, дансны авлага, бусад авлага, татварын авлага, урьдчилж төлсөн зардал, тооцооноос бүрдэнэ.
- vii. **Орлого:** Орлогыг хүлээн авсан эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжиж бүртгэлд тусгадаг. Эдийн засгийн ирээдүйн өгөөжийг тухайн Компани хүртэх магадлалтай мөн орлого болоод өртгийг үнэн бодитойгоор хэмжих боломжтой тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрдөг.
- viii. **Зардал:** Борлуулалт, маркетингийн болон ерөнхий удирдлагын зардлууд, цалин хөлсний зардал, эрсдэлийн зардал бусад үйл ажиллагааны зардлуудаас бүрдэнэ.
- ix. **Татвар:**

ААНОАТ:Тайлант хугацаанд СТОУС-ын дагуу санхүүгийн тайлагналын зорилгоор тодорхойлсон татварын өмнөх ашгийг Монгол улсын ААНОАТ-ын хууль, түүнд нийцүүлж гаргасан заавар, журмын дагуу татвараас чөлөөлөгдөх орлого болон татвар ногдуулах орлогоос хасагдахгүй зардлын зүйлсээр залруулан орлогын албан татварыг тодорхойлдог ба санхүүгийн тайлагналыг тасалбар болгох өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувь хэмжээг мөрдөн татварын тооцооллыг хийдэг.



